

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ГАЗРЫН  
2026 ОНЫ ХОЁРДУГААР УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

№	Арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)	Гүйцэтгэл хувь
<b>СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 1.1.ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ САЙЖРУУЛАХ</b>							
	<b>Гүйцэтгэлийн зорилт 1.1.1. Хууль тогтоомж, бодлого, шийдвэр, журам, стандартыг боловсруулах, шинэчлэх, санал хүргүүлэх</b>	<b>Улсын төсөв</b>	<b>Арга хэмжээнүүдийн биелэлт (тоо)</b>	-	100 хувь		93,25%
1	1.1.1.1 Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах.	Улсын төсөв	Боловсруулсан төсөл	-	1	Монгол Улсын Их Хурлын 2025 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 114 дүгээр тогтоолын хүрээнд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах, хяналт шалгалтын давхардал, хийдэл, хүнд суртлыг арилгах зорилгоор Засгийн газраас холбогдох байгууллагуудад мөрдөгдөж буй хууль, дүрэм, журам, стандартыг судлах чиглэл өгсний дагуу холбогдох хуулийн төслийг боловсруулах ажлыг гүйцэтгэх чиглэл өгсөн. Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын тушаалаар байгуулагдсан Ажлын дэд хэсгийн үйл ажиллагааны хүрээнд Төрийн хяналт шалгалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тавигдах	90%

					<p>шаардлагад нийцүүлэн эхний хувилбарыг боловсруулан, 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр ЗГХХГ-ын цахим хуудаст байршуулсан. Түүнчлэн уг хуулийн төслийн 2 дахь хувилбарыг боловсруулах ажлыг нийт 3 удаагийн хэлэлцүүлэг, салбарын улсын байцаагч нар, иргэдээс ирүүлсэн саналын хүрээнд саналыг тусган боловсруулсан. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн үзэл баримтлал, танилцуулгыг боловсруулж, РРТ танилцуулгыг бэлтгэж Тэргүүн Шадар Сайдад танилцуулсан. 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар уг хуулийн үзэл баримтлалыг танилцуулсан. Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 11 дүгээр хуралдааны тэмдэглэлээр өргөн хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулахыг даалгасны дагуу 2026 оны 04 дүгээр сарын 01-10-ны өдрүүдэд салбарын хяналтын улсын /ахлах/ байцаагчид, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын төлөөлөлд салбар бүрээр оролцогчдыг 5 хэсэгт хуваан Засгийн газрын XI байр "Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах төв"-д хэлэлцүүлэг зохион байгуулсан. Нийт 5 удаагийн хэлэлцүүлэгт хувийн хэвшил болон улсын байцаагч нарын нийт 138 төлөөлөгч оролцсон ба нийт 33 саналыг хуулийн төслийн үзэл баримтлалын төсөлд тусгаж ажилласан болно.</p> <p>Төр-Иргэний хяналтын тухай хуулийн үзэл баримтлалыг батлуулахаар 2026 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд руу хүргүүлсэн. Тус хуулийн үзэл баримтлалыг хамтран батлуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яам болон Сангийн яам руу илгээсэн ба тус яамдаас хариу санал</p>	
--	--	--	--	--	---	--

					<p>хүргүүлсэн байсныг хүлээн авч, үзэл баримтлалын төсөлд холбогдох саналыг тусган 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд руу хүргүүлсэн. Одоогоор хуулийн төслийн үзэл баримтлалыг Засгийн газрын хуралдаанаар дахин хэлэлцүүлэхээр бэлтгэж, ЭЗХЯ-нд хүлээлгэн өгсөн.</p> <p>Мөн ЗГХХГ-ын даргаас өгсөн чиглэлийн дагуу Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийг бусад газар, нэгжийн төлөөллийг оролцуулан тухай бүр хурлыг зохион байгуулах, холбогдох санал, судалгааг гаргуулан авч, нэгтгэн ажиллаж байна.</p> <p>2.ЗГХХГ-ын дүрмийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, бусад газруудаас санал авч, нэгтгэх ажлыг хийж гүйцэтгэж байна.</p>	
2	1.1.1.2 Төрийн хяналт шалгалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/ батлагдаж хэрэгжиж эхлэхтэй холбоотой дүрэм, журам, стандарт боловсруулахад арга зүйн дэмжлэг үзүүлэх.	Улсын төсөв	Санал өгсөн төсөл, орж ажилласан ажлын хэсэг (тоо)	-	<p>Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахтай холбогдуулан холбогдох судалгаа, баримт бичигт дүн шинжилгээ хийсэн. Үүнд:</p> <p>1.Зөрчлийн тухай хуулиас салбарын хяналт, зөрчлийн төрөл, шийтгэл, санкцын харьцуулсан судалгаа;</p> <p>2.Салбарын хяналтыг хэрэгжүүлж буй холбогдох байгууллагуудаас хяналтын чиглэл, мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын жагсаалтыг авч дүн шинжилгээ;</p> <p>3.Төрийн хяналт шалгалтын хууль шинэчлэн боловсруулж буйтай холбогдуулан уг хуулийг дагах 90 хуульд нэмэлт, өөрчлөлт чиглэлээр судалгаа;</p>	98%

					<p>4.Салбарын хяналтын /Нийт 11 яам, 3 агентлаг/ хууль тогтоомжийн судалгааг үндэслэн хяналтын давхардлыг хяналт хуудасны судалгаа;</p> <p>5.2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд салбарын улсын байцаагч нарт гаргасан гомдол мэдээллийн судалгаа;</p> <p>6.Төсвийн ерөнхийлөн захирагч, болон хяналт шалгалт хийх хүрээг тодорхойлох;</p> <p>7.Салбарын хуулиудад улсын байцаагчийн нэр томъёоны талаарх судалгаа;</p> <p>8.Олон нийтийн хяналтын зөвлөлийн талаарх хууль эрх зүйн зохицуулалт, төсөв санхүү, гүйцэтгэсэн ажлын үр дүнгийн талаарх судалгаа;</p> <p>9.Хяналт, шалгалт, хяналт шалгалт нэр томъёоны тайлбарын судалгаа;</p> <p>10.Монголбанкны оноожуулах системийн талаарх судалгаа;</p> <p>11.Хяналт шалгалтын байгууллагын түүхэн товчооны судалгаа;</p> <p>12.Салбарын хяналтын процессыг Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу процессын зураглал;</p> <p>13.Хуулийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх процессын зураглал;</p> <p>14.ЗГХХГ-ын үндсэн болон нийтлэг нийтлэг чиг үүргийн хүрээнд дагаж мөрдөж буй хууль тогтоомжийн судалгаа.</p>		
3	1.1.1.3 Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл үзэл баримтлалын	Улсын төсөв	Боловсруулж, хүргүүлсэн санал (тоо)	-	2	Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн үзэл баримтлал, танилцуулгыг боловсруулж, РРТ танилцуулгыг бэлтгэж Тэргүүн Шадар Сайдад танилцуулсан. 2026 оны 03 дугаар сарын 25-	100%

	төсөл, танилцуулга боловсруулах.					ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар уг хуулийн үзэл баримтлалыг танилцуулсан. Засгийн газрын хуралдаанаар үзэл баримтлалыг батлуулах талаар дахин хэлэлцүүлэхээр хүлээж байна.	
4	1.1.1.4 Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан "Байгууллага, албан тушаалтанд хяналт тавих нийтлэг журам"-ын төсөл боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлэх.	Улсын төсөв	Арга хэмжээнүүдийн биелэлтийн дундаж (хувь)	-	1	Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т заасан "Захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт хийх нийтлэг журам"-ыг боловсруулах ажлын хэсэг нийт 3 удаа хуралдан журмын төслийг боловсруулж, ЗГХХГ-ын дотоод нэгжүүд, 2025 оны 04 дүгээр сард ЗГ-ын гишүүдээс саналыг авч журмын төслийг эцэслэн боловсруулж, ЗГХЭГ-т хүргүүлэхэд бэлэн болгосон. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/182 дугаар тушаалаар ажлын хэсэг дахин байгуулагдсан. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд Засгийн газар дахь хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд уг журмын агуулгыг оруулахаар төлөвлөн ажиллаж байна.	85%
	<b>Гүйцэтгэлийн зорилт 1.1.2 Хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр судалгаа, шинжилгээ хийх, бусад байгууллагатай хамтран ажиллах</b>	Улсын төсөв	<b>Арга хэмжээнүүдийн биелэлтийн дундаж (хувь)</b>	-	100%		<b>100%</b>
5	1.1.2.1 Хууль тогтоомжийн төсөл боловсруулахад холбогдох тандалт судалгаа, зардлын	Улсын төсөв	Судалгааны тайлан (тоо)	-	3	УИХ-ын 2025 оны 114 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан аргачлалын	100%

	тооцоо, үр нөлөөний судалгаа хийх чиглэлээр бусад байгууллага, судлаачтай хамтран ажиллах.					дагуу Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн тандан судалгааны ажил, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын хүрээнд үр нөлөөний судалгааны ажил, зардлын тооцоо хийх ажлуудыг мэргэжлийн судалгааны байгууллагууд болох "Хууль судлалын төв" НҮТББ, Үндсэн хуульт ёс сан, "Эрх зүйн соёл" НҮТББ, "Очирт цэцэн оюун боловсролын холбоо" ТББ, "Нийгэм улс төрийн боловсрол" НҮТББ-уудтай үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж, хамтран ажилласнаар гэрээний хэрэгжилтийг хангуулан гэрээ дүгнэсэн акт үйлдэж, 5 судалгааны ажлын үр дүн болох судалгааны тайланг хүлээн авсан.	
6	1.1.2.2 Хууль тогтоомжийг боловсронгуй болгох, шинэчлэх, хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд холбогдох сургалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөн зохион байгуулах чиглэлээр бусад байгууллагатай хамтран ажиллах.	Улсын төсөв	Хэрэгжүүлсэн ажлын тоо (хувь)	0	1	1.Төрийн хяналт шалгалтын тухай Шинэчилсэн найруулга/ хуулийн төслийн үзэл баримтлалын төсөлд Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран салбар бүрийн хуулийн этгээдийн төлөөлөлтэй нийт 2 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Мөн Эдийн засаг хөгжлийн яамнаас зохион байгуулсан "Уул уурхайн салбарын 7 хоног" хэлэлцүүлэгт оролцсон. Хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг хэлэлцүүлэх ажлын хүрээнд нийт 85 хуулийн этгээдийн төлөөллөөс нийт 63 саналыг авч, тусгасан. Түүнчлэн яамнуудын салбарын хяналтын улсын байцаагч нартай салбар тус бүрээр нийт 15 удаагийн уулзалтыг зохион байгуулж, үүсэж буй асуудал, бэрхшээлүүдийн талаар нийт 94 саналыг авч, хуулийн төслийн үзэл баримтлалын төсөлд тусгаж ажилласан болно.	100%

					<p>2.Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газар хамтран 2026 оны 03 дугаар сарын 03-ны өдөр “Төрийн үйлчилгээний сэтгэл ханамж, тулгарч буй хүндрэл” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгууллаа.</p> <p>Тус хэлэлцүүлэг нь төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг боловсронгуй болгох зорилтын хүрээнд хэрэгжиж буй хамтын ажиллагааны төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдсан юм.</p> <p>Энэхүү хэлэлцүүлэгт нийслэлийн нутгийн захиргааны байгууллагад иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын судалгааны үр дүнг танилцуулсан.</p> <p>3.Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 11 дүгээр хуралдааны тэмдэглэлээр өргөн хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулахыг даалгасны дагуу 2026 оны 04 дүгээр сарын 01-10-ны өдрүүдэд салбарын хяналтын улсын /ахлах/ байцаагчид, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын төлөөлөлд салбар бүрээр оролцогчдыг 5 хэсэгт хуваан Засгийн газрын XI байр “Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах төв”-д хэлэлцүүлэг зохион байгуулсан. Нийт 5 удаагийн хэлэлцүүлэгт хувийн хэвшил болон улсын байцаагч нарын нийт 138 төлөөлөгч оролцсон ба нийт 33 саналыг хуулийн төслийн үзэл баримтлалын төсөлд тусгаж ажилласан болно.</p>	
<b>Гүйцэтгэлийн зорилт 1.1.3 хуулиар харьяалуулсан чиг үүрэгтэй холбоотой байгууллага, албан тушаалтны гаргасан</b>	<b>Улсын төсөв</b>	<b>Арга хэмжээнүүдийн биелэлтийн дундаж (хувь)</b>	-	<b>100%</b>		<b>90%</b>

шийдвэрийг бүртгэж, холбогдох шийдвэрт хууль, эрх зүйн дүгнэлт хийх							
7	1.1.3.1 Хяналт шалгалтын удирдамжийн хүрээнд шалгуулагч байгууллагын эрх бүхий этгээдийн гаргасан шийдвэрийг хянаж, шаардлагатай тохиолдолд тайланд санал, дүгнэлт өгөх	Улсын төсөв	Хянаж, санал, дүгнэлт өгсөн шийдвэрийн тоо	-	-	<p>1.Мэдээллийн технологийн нэгдсэн холбооноос 2026 оны 26/05/06/01 дугаар албан бичгээр ирүүлсэн гомдолд дурдсан асуудлын хүрээнд хяналт шалгалт хийж, бодлого, шийдвэр болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг нотлох баримтад тулгуурлан газар дээр нь хянан үзэж, хяналт-шинжилгээ хийх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, цаашид шийдвэрлэх шаардлагатай асуудлыг тодорхойлон хэрэгжүүлэгч байгууллагын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэгдсэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны зарим үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай удирдамжийн дагуу байгуулагдсан ажлын хэсэгт орж, хууль, эрх зүйн туслалцаа үзүүлэн ажиллаж байна.</p> <p>2.“Туулын хурдны зам” төслийг зогсоосонтой холбогдуулан хяналт шалгалт хийх хууль зүйн үндэслэлийг судалж зөвлөгөө, мэдээллээр хангаж, хууль зүйн дүгнэлт гаргасан.</p> <p>3. Цахим орчинд нийтэлсэн тусгай зөвшөөрөл болон тендерийн үйл ажиллагаатай холбоотой гаргасан иргэдийн мэдээлэлтэй холбоотойгоор асуудлыг судалж хууль зүйн дүгнэлт хийж, зөвлөгөө, мэдээллээр хангаж ажилласан.</p> <p>4.Архи согтууруулах ундааны тусгай зөвшөөрлийн талаар судалж хууль зүйн мэдээллээр хангаж ажилласан.</p> <p>5.Бар код авах процессын талаар судалж мэдээллээр хангаж ажилласан.</p>	90%

<p><b>Гүйцэтгэлийн зорилт 1.1.4</b>  <b>Хяналт хэрэгжүүлэх газраас боловсруулсан Засгийн газрын шийдвэрийн төслийн хууль зүйн үндэслэлийг хянах, санал боловсруулах</b></p>	<p>Улсын төсөв</p>	<p><b>Арга хэмжээнүүдийн биелэлтүүдийн дундаж (хувь)</b></p>	<p>-</p>	<p>100%</p>		<p>100%</p>	
<p>8</p>	<p>1.1.4.1 Засгийн газраас гарсан шийдвэрийн бүртгэлийг хөтөлж, бусад газрыг мэдээллээр хангах</p>	<p>Улсын төсөв</p>	<p>Хэрэгжилтийн (хувь)</p>	<p>-</p>	<p>100 хувь</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын хуралдааны цахим системд байршуулсан Засгийн газрын тогтоол, Засгийн газрын тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамж, албан даалгаврын нэгдсэн цахим санг /2025, 2026 он/ үүсгэсэн. Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас эрх олгосны дагуу Засгийн газрын хуралдаанаас гарсан шийдвэрийг тухай бүр хүлээн авч цахим архив үүсгэн ажиллаж байна. 2026 оны 1 дүгээр улиралд ЗГ-ын тогтоол 4, ЗГ-ын тэмдэглэл 7, Ерөнхий сайдын захирамж 1, Албан даалгавар 1, нийт 13 шийдвэр тус тус албажиж ирсэн байна. ХЭЗГ-аас байгууллагын албан хэрэг хөтлөлтийн Able системийн "тушаал, шийдвэр" цэсэд цахим архив үүсгэж, газар, хэлтсийн дарга нарт шийдвэрийг тухай бүр хүргүүлж мэдээллээр хангаж байна. 2026 оны хагас жилийн байдлаар: Засгийн газрын тогтоол 11, Хуралдааны тэмдэглэл 18, Ерөнхий сайдын албан даалгавар 3, нийт 32 шийдвэрийг байршуулсан.</p>	<p>100%</p>
<p><b>2.ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ</b></p>							
<p><b>Гүйцэтгэлийн зорилт 2.1</b>  <b>Хууль болон дүрэмд заасан нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх</b></p>	<p>Улсын төсөв</p>	<p><b>Арга хэмжээнүүдийн биелэлтийн дундаж (хувь)</b></p>	<p>-</p>			<p>100%</p>	

9	2.1.1 Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас боловсруулсан Засгийн газрын шийдвэрийн төслийг боловсруулах, хянах.	Улсын төсөв	Хянуулахаар ирүүлсэн шийдвэрийн төслүүдээс хянагдсан (тоо)	-	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас Засгийн газрын хуралдаанд танилцуулах, хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлаар бусад газраас боловсруулан ирүүлсэн нийт 6 төслийг хянаж, санал өгсөн. 1.Тандалт судалгаа, бодлого төлөвлөлтийн газраас боловсруулсан Яам болон агентлагийн чиг үүргийн шинжилгээний тайланг танилцуулах Засгийн газрын тэмдэглэлийн төсөл болон танилцуулгыг боловсруулахад эрх зүйн дэмжлэг үзүүлсэн. 2.Үнэлгээ мониторингийн газраас Засгийн газрын ээлжит хуралдаанд танилцуулах шуурхай үүрэг даалгаврын биелэлтийн танилцуулга болон тэмдэглэлийн төслийг 7 хоног бүр хянаж, санал өгсөн.	100%
10	2.1.2 Хууль зүйн зөвлөгөө, мэдээллээр хангах, байгууллагыг шүүхэд төлөөлөх үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх.	Улсын төсөв	Шүүхэд байгууллагыг төлөөлж ажилласан хэргийн (тоо)	-	100%	100%

					<p>дугаар сарын 10-ны өдөр шүүхэд төлөөлөгчөөр оролцсон. Шүүхээс Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 131.1.1-д заасан шинээр илэрсэн нөхцөл байдал биш байна гэж хэргийг авч үзээд, Захиргааны Хэргийн Давж заалдах Шатны Шүүхийн 2025 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 221/МА2025/0556 дугаартай магадлал, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 128/ШШ2025/0454 дугаартай шийдвэрийг дахин хянахгүй шийдвэрийг гаргасан.</p> <p>2.ЗГХХГ-т холбогдуулан гаргасан иргэн У, Ж нарын нэхэмжлэлтэй захиргааны 2 хэргийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хариуцагчийг төлөөлж оролцсон. Анхан шатны шүүх хуралдаан 2026.01.12, 2026.03.06-ны өдрүүдэд болж нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.</p> <p>3.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2026.04.22-ны өдрийн .... дугаар магадлалаар иргэн У-н давж заалдах журмаар гаргасан гомдлыг хангахгүй орхиж, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдсэн.</p> <p>4.Т.Нурсаулегийн Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын ахлах хянан шалгагчид холбогдох захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож хариу тайлбар холбогдох нотлох баримтуудыг хүргүүлээд байна. 2026 оны 04 дүгээр сарын 16 өдрийн 128/ШЗ2026/3070 дугаартай нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай шүүгчийн захирамж гарсан.</p>	
--	--	--	--	--	--	--

						5.Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд иргэн Г.Анараас гаргасан “Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргын Б/41 дүгээр захиргааны шийдвэрийг хүчингүй болгуулах” шаардлага бүхий нэхэмжлэлтэй шүүх хуралд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож байна.	
11	2.1.3 Байгууллагын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт орж ажиллах	Улсын төсөв	Орж ажилласан ажлын хэсэг (тоо)	-	100%	<p>1.Засгийн газрын харьяа төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын бүтэц, зохион байгуулалтад чиг үүргийн шинжилгээ хийж, давхардлыг тодорхойлж, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээ, чиг үүрэг, нэгжийн зохион байгуулалтын жишиг бүтцийг тогтоох зорилготой Монгол Улсын сайд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 123 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж яам, агентлаг, 21 аймаг, түүний харьяа байгууллагаас ирүүлсэн судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийж, холбогдох тайланг хүргүүлсэн.</p> <p>2.ЗГХХГ-ын даргын 2026 оны 03 сарын 03-ны өдрийн А/14 дүгээр тушаалаар байгуулагдсан хиймэл оюунд суурилсан үнэлгээний систем нэвтрүүлэх ажлын хэсэгт ХЭЗГ-ын төлөөлөл ажиллан “Хамтран ажиллах Санамж бичиг”-ийн төслийг хянаж, санал хүргүүлсэн.</p> <p>3.ЗГХХГ-ын даргын 2025 оны 12 сарын 30-ны өдрийн А/197 дугаар тушаалаар “Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл”-д ХЭЗГ-с 2 удаагийн хуралдаанд оролцож, санал хүргүүлж ажилласан.</p> <p>4.ЗГХХГ-ын даргын 2026 оны А/11 дүгээр тушаалаар байгуулагдсан “Эрсдэлийн удирдлагын хороо”-д гишүүнээр ажилласан. ХЭЗГ-т үүсэж болох эрсдэлийг тодорхойлж,</p>	100%

					<p>асуудлыг шийдвэрлэх санал боловсруулж, Байгууллагын эрсдэлийн хороонд хүргүүлсэн.</p> <p>5.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны зарим үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай удирдамжийн дагуу Мэдээллийн технологийн нэгдсэн холбооноос 2026 оны 26/05/06/01 дугаартай албан бичгээр ирүүлсэн гомдолд дурдсан асуудлын хүрээнд хяналт шалгалт хийж, бодлого, шийдвэр болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг нотлох баримтад тулгуурлан газар дээр нь хянан үзэж, хяналт-шинжилгээ хийх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, цаашид шийдвэрлэх шаардлагатай асуудлыг тодорхойлон хэрэгжүүлэгч байгууллагын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэгдсэн ажлын хэсэгт орж ажиллаж байна.</p> <p>6.Улсын хоёрдугаар төв эмнэлгийн үйл ажиллагаа, чиг үүргийн шинжилгээ бүтэц зохион байгуулалтын ажлын хэсэгт орж ажиллаж байна.</p>	
12	2.1.4 Төрийн байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн албан бичигт хариу өгөх, санал, дүгнэлт боловсруулах.	Улсын төсөв	Ирүүлсэн албан бичигт хариу хүргүүлсэн (тоо)	-	<p>1.Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад "Мон Аэр тур" ХХК нь тус компанийн ашиглаж байгаа газарт байгуулсан байгууламжийг нураах талаар Иргэний нисэхийн ерөнхий газрын мэдэгдэлд гомдолтой байгаа тухай 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 02/25-25 дугаартай албан бичгээр мэдээлэл хүргүүлсэн байна. Мэдээллийг судлан үзэхэд, Иргэний нисэхийн ерөнхий газраас 2025 оны 06 дугаар "Мон Аэр тур" ХХК нь тус газрыг Төв аймгийн Сэргэлэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталсан 2022 оны сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны</p>	100%

					<p>дагуу Төв аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас зарласан дуудлага худалдаанд оролцон шалгарч, Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 04167-А/741/2022 дугаартай шийдвэрийг үндэслэж, Сэргэлэн сумын 4 дүгээр баг Бөхөгийн хөндий гэх газарт "Агаарын тээврийн ачаа, зуучлалын агуулах" зориулалтаар 0,7106 га буюу 7106 м.кв газрыг 5 жилийн хугацаатай Сэргэлэн сумын эрх бүхий албан тушаалтан болон "Мон Аэр тур" ХХК-ийн хооронд гэрээ байгуулсан байна. Иймд Иргэний нисэхийн ерөнхий газарт 2026 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн 01/101 дугаартай хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хууль тогтоомжийн хүрээнд хангаж ажиллах талаар ЗГХХГ-ын даргын албан бичиг явуулсан.</p> <p>2.Төрийн албаны зөвлөлөөс 2026 оны 03/113 дугаартай иргэн Д.Энхтайваны гаргасан өргөдөл, гомдолтой холбоотойгоор ирүүлсэн албан бичгийг судалж холбогдох дүгнэлтийг боловсруулж хүргүүлсэн.</p> <p>3.Иргэн Ч.Уранчимэгээс ЗГХХГ-ын Хяналт шалгалтын газарт хандаж гаргасан гомдолд хууль зүйн дүгнэлт бичиж удирдлагад танилцуулсан.</p> <p>4.Мэдээллийн технологийн нэгдсэн холбооноос ирүүлсэн өргөдлийн дагуу Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас хийгдэх ажлын хуваарийн дагуу Хууль эрх зүйн газраас санал, тайлбар хүргүүлсэн.</p>
--	--	--	--	--	---

13	2.1.5 Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх.	Улсын төсөв	Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо (тоо)	-	1.Иргэн У.Ганболдоос Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах төвийн 11-11 тусгай дугаарт хандаж Мэргэжлийн хяналтын байгууллагыг сэргээх тухай хүсэлтэд хариу хүргүүлсэн. 2.Монголын барилгын үндэсний ассоциациас ирүүлсэн захиргааны хэм хэмжээний актыг Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэх тухай хүсэлтийг холбогдох байгууллагад шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн.	100%
----	--	-------------	---	---	--	------

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

№	Арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилто т түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)	Гүйцэтгэл хувь
1	Бусад газруудтай хамтран ажиллах, ажлын хэсэгт орж ажиллах.	Улсын төсөв	Гүйцэтгэлийн (хувь)	0	100%	1.Байгууллагын бусад нэгжүүдээс дотоод албан бичгээр ирүүлсэн 3 журмын төсөлд санал хүргүүлсэн. 2.“Төрийн байгууллагын үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2026 оны 119 дүгээр тогтоол батлагдсантай холбогдуулан чиг үүргийн шинжилгээ хийхэд дэмжлэг үзүүлэн 3 агентлагийн чиг үүргийн шинжилгээг хийж, холбогдох байгууллагуудтай холбогдож мэдээлэл солилцож ажилласан. Холбогдох дата мэдээллийг цэвэрлэх, мэдээллийг нэгтгэх ажлыг хийж гүйцэтгэсэн. 3.Бусад газар, нэгжүүдийн үйл ажиллагаанд шаардлагатай эрх зүйн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Тухайлбал, -Тандалт судалгаа, бодлого төлөвлөлтийн газраас боловсруулсан “Төрийн байгууллагад процессын дахин инженерчлэл хийх нийтлэг аргачлал”-ыг хянаж, засварлан тус газарт	100%

					<p>буцаан хүргүүлсэн. Тандалт судалгаа, бодлого төлөвлөлтийн газраас боловсруулсан Яам болон агентлагийн чиг үүргийн шинжилгээний тайланг танилцуулах Засгийн газрын тэмдэглэлийн төсөл болон танилцуулгыг боловсруулахад эрх зүйн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>-Үнэлгээ мониторингийн газраас Засгийн газрын ээлжит хуралдаанд танилцуулах шуурхай үүрэг даалгаврын биелэлтийн танилцуулга болон тэмдэглэлийн төслийг 7 хоног бүр хянаж, санал өгсөн. Мөн тухайн газраас боловсруулсан тушаалын төслийг хянасан, санал өгсөн.</p> <p>-Тамгын газраас боловсруулж буй тушаал, шийдэрийн төслийн хууль зүйн үндэслэлийг хянасан.</p> <p>Үндэсний аудитын газраас ирүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн зарим орон тоонд өөрчлөлт оруулах санал танилцуулж, тушаалын төслийг хянасан. Аудитын албан шаардлагыг хэрэгжүүлж, гэрээт болон зөвлөх гэрээт албан тушаалыг төрийн үйлчилгээний ангилал зэрэглэлд хамаарах албан тушаалд хамааруулсан.</p> <p>Тамгын газраас боловсруулсан "Байгууллагын эцэг, эхийн зөвлөлийн ажиллах журам"-ын төслийг хянасан.</p> <p>ЗГХХГ-ын даргын даалгасны дагуу зарим албан хаагчдад сонсох ажиллагаа хийсэнтэй холбоотой танилцуулга бэлтгэж, ДХАГ-т хүргүүлсэн.</p> <p>Албан хаагчдын сахилга бат, цаг ашиглалтыг сайжруулах зорилгоор цаг бүртгэлийн төхөөрөмжид хүний хувийн "биометрик" мэдээллийг ашиглах талаарх хууль эрх зүйн</p>	
--	--	--	--	--	---	--

						<p>зохицуулалтыг судалж, холбогдох саналыг ТГ, ДХАГ-т хүргүүлсэн.</p> <p>-Дотоод хяналт, аудитын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу дотоод аудит хийх тухай удирдамжийн хүрээнд хяналт шалгалт хийх тухай асуудалд хууль зүйн зөвлөгөө, арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан. Засгийн газрын 2015 оны 483 тогтоолоор "Дотоод аудитын дүрэм" баталсан. Мөн Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах. Тус журмын зохицуулалтаар дотоод хяналт болон дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар арга зүйн зөвлөгөө өгсөн.</p>	
2	ЗГХХГ-ын бусад газар, хэлтсүүдээс санал авахаар ирүүлсэн дотоод бичигт хариу хүргүүлэх.	Улсын төсөв Улсын төсөв	Санал авахаар ирүүлсэн албан бичгүүдэд хариу хүргүүлсэн (хувь)	-	100%	Бусад газар, хэлтсээс ирүүлсэн нийт 29 албан бичигт хариу хүргүүлж ажилласан байна.	100%
3	ЗГХХГазар ЗГХЭГазартай хамтран ажиллах	Улсын төсөв	Гүйцэтгэлийн (хувь)	0	100%	1.Ерөнхий сайдад хандаж иргэдээс ирүүлсэн 2000 гаруй өргөдөл, гомдлыг тухайн салбарт хамаарах асуулт, агуулгаар нь ангилж ЗГХЭГазарт хүргүүлсэн.	100%

**ТАЙЛАНГ ҮНЭЛСЭН:**

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН ДАРГА  
Тэмдэг

*(Handwritten signature)*



П. БАТБААТАР  
2024.6.10  
(огноо)

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:**

ДОТООД ХЯНАЛТ, АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА.....



РДЭЖИД

2026.06.16

(огноо)

**ТАЙЛАГНАСАН:**

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ.....



М.ЦОЛМОН

2026.06.12

(огноо)